

**Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани”)
Үйл ажиллагааны талаархи шинэчилсэн мэдээлэл**

Петро Матад (AIM:MATD) нь Монгол Улсад явуулж буй хайгуулын үйл ажиллагааныхаа талаархи шинэчилсэн мэдээллийг хүргэж байгаадаа таатай байна.

ДТ-2 цооногийн өрөмдлөг

Петро Матадын Давсан Толгой-2 цооногийн (“ДТ-2” гэх) өрөмдлөгийн ажил үргэлжилж байна. Механик хүндрэлийн улмаас саатал гарсан бөгөөд асуудлыг шийвэрлэсний дараа үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Одоогоор цооногийн завсрын хэсэгт буюу өрөмдлөгийн өмнө урьдчилан төлөвлөсөн 1,091.5 метрийн гүнд бэхэлгээний янданг суулгах ажил явагдаж байна. Цооногийн өрөмдлөгийг цааш үргэлжлүүлэхийн өмнө завсрын хэсгийн цооногийн геофизикын бичиглэл, яндангийн бэхэлгээ болон цемент цутгалтын ажлууд хийгдэнэ. Өрөмдлөг төлөвлөсөн гүндээ хүрч, анхны үр дүн гарсаны дараа Компани дараагийн мэдээллийг хүргэх болно.

2D буюу 2 хэмжээст чичирхийллийн судлагаа болон ДТ-1 цооногоос авсан дээжүүдийн лабораторын шинжилгээний үр дүн

Өмнөх мэдээлэлд дурдсанчлан Петро Матадын ДТ-1 цооногоос авсан дээжүүдийг АНУ-ын Уэдэрфорд олон улсын лаборатор (Weatherford international laboratories) руу давхарга болон газрын тосны шинж чанарыг тодорхойлуулахаар илгээсэн. Туршилтын ажил одоогоор үргэлжилж байгаа бөгөөд 3-4 долоо хоногийн дараа үр дүн нь гарна хэмээн үзэж байна.

IV ба V талбайдын геофизикын судлагаа

Компанийн IV ба V талбайд 345 км шугамаар 2 хэмжээст чичирхийллийн судлагааны ажлыг 2010 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр гүйцэтгэж дууслаа. Чичирхийллийн судлагаагаар олж авсан мэдээллийг боловсруулахаар АНУ руу илгээсэн бөгөөд боловсруулалтын дараа Петро Матадын техникийн хэлтсийн ажилтнууд мэдээллийн тайлалыг хийх юм. Хүндийн хүчний гүйцээх судлагаа үргэлжилж байна.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүгэн хянаж, зассан болно. Доктор Күүгэн нь Хойд Америк болон олон улсын газрын тосны хайгуул, ашиглалтын салбарт 29 жил ажилласан туршлагатай Газрын тосны геологич юм.

Тэрээр Америкын Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкын Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Компанийн талаархи нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Даглас Жэй МакГэй – Гүйцэтгэх Захирал
+976 11 331099
Уэст Хаус Секюритиз Лимитед
Ричард Бати/Питр Нортон +44 (0)20 7601 6100

Мэдээллийн хянан тохиолдуулагчдад зориулсан санамж:

Петро Матад Лимитед компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулахад чиглэсэн группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах тухай гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол Улсын зүүн алсын нутаг дэвсгэрт орших 14,250 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны талбай болох ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх). Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайнууд нь Монгол Улсын төв хэсэгт орших бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V тоот компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан бөгөөд компанийн албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг болно.